

БАТЛАВ

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА Ц.БЭХБАЯР

2025 оны 10 дугаар сарын 08

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 10 дугаар сарын 08

Мөрөн сум

№	Хийх ажлын чиглэл	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
НЭГ. Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт болон байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэнд хяналт тавих				
1	Байгууллагын зорилго, дотоод журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн	Бүх ажилчид байгууллагын дотоод журам, алсын хараа, эрхэм зорилго, өөрийн эрх, үүрэг хариуцлагыг мэддэг болох
2	Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилт, байгууллагын удирдлагаас өгсөн чиг үүргийн хувиарлалт, үүрэг даалгавар, тушаал шийдвэрийн биелэлтийг тооцож ажиллах	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн, Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Байгууллагын үйл ажиллагааны чанар бүтээмж дээшилж ажлын үзүүлэлт сайжирна
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийн хяналт тавих	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн, Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Ажил олгогч болон ажилтан нар хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлж албан хаагчдын ёс зүй, хариуцлага дээшилнэ
ХОЁР. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн чиглэлээр тавих хяналт				
1	Байгууллагын хөрөнгийн бүртгэлжилт, эд хариуцагч нарын бүртгэлд хяналт тавих	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн	Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэлээр тавих хяналт сайжирна

2	Шатахуун бусад бараа материалын зардалд хяналт тавих	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн	Зардлыг хянах, боломжит хэмжээнд бууруулахад үр дүн гарна
3	Ажилтнуудын цаг ашиглалт, бүртгэлийн хяналт	Сар бүр	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Ажлын бүтээмж нэмэгдэнэ
4	Шилэн дансны мэдээлэлд хяналт тавих	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн	Мэдээлэл цаг хугацаандаа, бүрэн орсон байна
ГУРАВ. Байгууллагын ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, эрүүл аюулгүй байдлын талаар тавих хяналт				
1	Ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөлд үнэлгээ, хяналт хийх	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн	Ажлын байран дээр учирч болзошгүй эрсдлийг илрүүлэх, бууруулах, арилгах арга хэмжээг авсан байна
2	Байгууллагын эзэмшлийн автомашины бүрэн бүтэн байдал, замд гарахад аюулгүй байдлыг хангасан эсэхэд хяналт тавих, шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангасан эсэх	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн	Ажилчид замд зорчиход найдвартай, аюулгүй байдлаар хангагдсан байна
ДӨРӨВ. Дотоод хяналтын ажлыг тайлагнах				
1	Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр байгууллагын удирдлагад мэдээлж, зөвлөмж хүргүүлэн ажиллана	Тухай бүр	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн, Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөний хэрэгжилт сайжирна
2	Тухайн жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг оны эцэст нийт ажилтнуудад танилцуулна	IV улиралд	Өмчийн хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн, Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж дараа оны төлөвлөгөөнд ажилтнуудын санал хүсэлтийг тусган ажилласнаар дотоод хяналтын ажлын үр дүн сайжирч ил тод байдлыг хангана

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:



А.ЭНХЖАРГАЛ

(ӨМЧИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН)